

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

2013.04.26

№ 2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2013 оны 4 дүгээр сарын 3-ны болон 5-ны өдрүүдэд хуралдсан бөгөөд хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал удирдан явуулав.

2013 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр МБЗ нь Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (МБСГ)-аас танилцуулсан макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлвийн талаарх дараах асуудлыг авч хэлэлцлээ.

Дэлхийн эдийн засгийн төлөв 2013 онд төдийлөн сайжрахааргүй, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурах төсөөллийг олон улсын судалгааны байгууллагууд хийгээд байна. Манай улсын хувьд уул уурхайн экспортын хүлээгдэж байсан огцом өсөлт тодорхой бус болсон, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн 6 сарын дотор эрс багассан нь төлбөрийн тэнцлийг алдагдалтай гарахад нөлөөлж байна. Тухайлбал, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оны 2 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 2.4 дахин буюу 342.3 сая ам.доллараар буураад байна. 2013 оны 2 дугаар сарын байдлаар зээлийн жилийн өсөлт 25.6 хувь, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 16.0 хувьд хүрсэн, харин экспортын орлого -3.9 хувь болж буурсан байна. МБСГ-аас боловсруулдаг инфляцийн хөтөч үзүүлэлтүүдийн тооцооны үр дүнгээр 2013 оны эхний 2 сард бодит M2 мөнгөний эрэлт, нийлүүлэлт дунджаар ижил түвшинд буюу мөнгөний нийлүүлэлт нь урт хугацааны тэнцвэрт түвшний орчим байна. Хэрэв энэ байдал цаашид хадгалагдана гэж үзвэл эдийн засгийн болон мөнгөний мөчлөгөөс инфляцид үзүүлэх дарамт бага байх боломжтой юм. Гэхдээ “Чингис” бондын хүлээгдэж буй зарцуулалт, Засгийн газартай байгуулсан санхүүгийн зуучлалын гэрээний хүрээнд банкуудад байршуулж буй төгрөгийн хадгаламж, Монголбанк, Засгийн газрын хамтарсан гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр 2013 оны сүүлийн хагаст мөнгөний нийлүүлэлт, зээлийн өсөлт нэмэгдэх хүлээлттэй байна.

2013 оны 2 дугаар сард төсвийн зарцуулалт төлөвлөснөөс 402.2 тэрбум төгрөгөөр дутуу буюу 60.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь хөрөнгийн зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс мэдэгдэхүйц бага байгаатай холбоотой байна. Харин төсвийн орлого 96.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монголбанкнаас хийсэн үйлдвэрлэлийн зөрүүний¹ шинжилгээгээр эдийн засгийн өсөлт одоогийн байдлаар потенциал түвшний орчимд байгаа бол 2013 онд үйлдвэрлэлийн зөрүү сөрөг түвшинд хүрч, эдийн засгийн өсөлт удаашрах төлөвтэй байна. Түүнчлэн Сангийн яамнаас гаргадаг Нэгдсэн түрүүлэгч индикаторын таамаглалаар ойрын 4-6 сарын хугацаанд эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарч болзошгүй байна.

Инфляцийн төсөөллөөр 2013 онд эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт харьцангуй бага, нийлүүлэлтийн доголдлыг арилгах зорилготой үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нөлөөгөөр 2013 оны эцэст инфляци 7.4 хувийн голчтой, 4.9-9.7 хувийн хооронд байх төсөөлөлтэй байна. Энэхүү суурь төсөөлөл нь мөнгөний бодлогын өнөөгийн төлөв

¹ Потенциаль ДНБ ба бодит ДНБ-ий зөрүү

өөрчлөгдөхгүй, төсвийн зарцуулалт 2013 оны батлагдсан хэмжээнд хийгдэнэ, төсвөөс гадуур бусад хөрөнгө оруулалт хийгдэхгүй, инфляцид нийлүүлэлтийн шалтгаантай дарамт үүсэхгүй, үнийг тогтворжуулах чиглэлээр Монголбанк, Засгийн газрын хамтарсан хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж, төрийн зохицуулалттай үнэ өсөхгүй зэрэг үндсэн нөхцлүүдэд үндэслэсэн байна.

МБЗ-ийн 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн хурлаар инфляци зорилтот түвшинг хангахаар байгаа үед зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжлийг дэмжих, улмаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах зорилгоор Монголбанкны бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 11.5 хувь болгох саналыг хэлэлцэв.

МБЗ-ийн ажиллах журмын дагуу Монголбанкны Ерөнхийлөгч мөнгөний бодлогын саналыг шүүмжлэх болон хамгаалах багийг тус тус томилсон болно. Бодлогын саналтай холбоотой хэд хэдэн асуудлаар шүүмжлэх баг байр сууриа илэрхийлсэн бол хамгаалах баг холбогдох тайлбарыг хийх байдлаар хэлэлцүүлэг өрнөлөө.

Шүүмжлэх баг юуны түрүүнд Төв банкны зүгээс мөнгөний бодлогын төлвийг сулруулсан хэдий ч, мөнгөний үзүүлэлтүүдэд дорвитой өөрчлөлт гараагүй байгаа талаар тодруулга авахыг хүслээ. Монголбанкны гаргаж буй бодлогын шийдвэр нь мөнгөний хэмжээ биш мөнгөний үнэ буюу хүүг үйл ажиллагааны зорилгоо болгож, түүнд нөлөөлөх арга хэмжээ гэдгийг хамгаалах баг онцолсон. Түүнчлэн бодлогын хүүний нөлөөллийн хэмжиж болохуйц үр дүн нь тодорхой хугацааны дараа гардаг бөгөөд 2013 оны 1 дүгээр сард гаргасан мөнгөний бодлогын шийдвэрийн бодит эдийн засагт үзүүлэх нөлөөг 1 сарын дотор тооцож гаргах нь хэцүү юм. Гэхдээ бодлогын хүүг бууруулсны дараах эхний үр дүн Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасны хүү болон банк хоорондын зах (БХЗ)-ын жигнэсэн дундаж хүү (ЖДХ) буурснаас харж болно. Мөн 2013 оны 2 дугаар сард хүүний коридорыг нэвтрүүлснээр бодлогын хүүний нөлөөлөл буюу мөнгөний бодлогын шилжих механизм, эдийн засагт шууд нөлөөлөх суваг илүү үр дүнтэй байх нөхцөл бүрдсэн, БХЗ-ын ЖДХ-ний хэлбэлзэл харьцангуй тогтворжсон байна.

Шүүмжлэх багийн зүгээс ханшийн өөрчлөлт нь хүүний өөрчлөлтөөс түргэн хугацаанд зах зээлд нөлөөлдөг, бодлогын хүүг бууруулснаар төгрөгийн ханш сулрах дарамт ихсэх үү? Мөн манай улсаас гадаад валют дүрвэж байгаа эсэх талаар лавлав. Үүнд хамгаалах баг хэдийгээр гадаад валютын гарах урсгал байгаа ч үүнийг дүрвэлт гэж үзэхгүй, дүрвэлт байгаа эсэхийг банкны салбарын хэмжээнд гадаад валютын харилцах, хадгаламжийн хэмжээ мэдэгдэхүйц буурсан уу гэдгээс харж болно. Одоогийн байдлаар тийм нөхцөл үүсээгүй, гадаад валютын дүрвэлт байхгүй гэсэн хариултыг өглөө.

Бодлогын хүүг бууруулснаар ханшид үзүүлэх дарамт, нөлөөлөл нь бага гэдгийг онцоллоо.

Шүүмжлэх багаас мөн бодлогын хүүг 1 нэгж хувиас илүү хувиар буулгах боломж байгаа эсэхийг лавлав. Үүнд хамгаалах багаас одоогоор бодлогын хүүг 1 нэгж хувиас илүү хэмжээгээр бууруулах нөхцөл бүрдээгүй байна. Түүнчлэн бодлогын хүүг огцом бууруулах нь гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны нөхцлийн тодорхойгүй байдал үргэлжилж, экспортын орлого буурч, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж болзошгүй үед оновчтой шийдвэр биш гэж үзсэн.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогын хүүг бууруулах саналыг тал бүрээс нь авч үзэн, өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийсний дүнд, инфляцийн хэтийн хандлага зорилтот түвшинтэй нийцтэй, эрэлтийн болон нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт багасахаар хүлээгдэж байгаа нь бодлогын хүүг бууруулах нөхцлийг бүрдүүлж байна гэсэн зарчмын байр суурьт санал нэгдлээ. Хурлыг удирдагч бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах талаар санал хураахад МБЗ-ийн олонхи гишүүд дэмжсэнээр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулахаар тогтов.

Бодлогын хүүг бууруулснаар мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулан, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн идэвхжлийг дэмжих боломжийг олгож буй хэдий ч, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдал, төлбөрийн тэнцэлд учрах дарамт зэргийг анхааралтай ажиглаж, цаашдын судалгаа, шинжилгээ, бодлогод харгалзаж үзэх нь зүйтэй гэдэгт зөвлөлийн гишүүд санал нэгдсэнээр МБЗ-ийн хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 11.5 хувь болгох шийдвэр гаргав.